



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Ашиглалтын тусгай зөвшөөрөл  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Уламжлалт бус газрын тосны нөөц батлагдсан Хавсралт-1-д заасан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл болон холбогдох бичиг баримтыг Ашигт малтмалын газраас Газрын тосны газарт шилжүүлсүгэй.

Хоёр. Уламжлалт бус газрын тосны нөөц батлагдсан Хавсралт-2-д заасан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж ажиллахыг Газрын тосны газар /Г.Өлзийбүрэн/-т үүрэг болгосугай.

Гурав. Уламжлалт бус газрын тостой холбогдсон Улсын болон хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи, судалгааны анхдагч баримт, тайлан, кадастрын бүртгэлийн мэдээллийг Газрын тосны газарт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмалын газар /Д.Үүрийнтуяа/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батхүү/, Ашигт малтмалын газар /Д.Үүрийнтуяа/, Газрын тосны газар /Г.Өлзийбүрэн/-т тус тус даалгасугай.


САЙД



Р.ЖИГЖИД

08 0320

Уул уурхайн яамны сайдын  
2015 оны 06 сарын 23 өдрийн  
116 тоот тушаалын Хавсралт 1



Ашигт малтмалын газраас Газрын тосны газарт шилжүүлэх  
уламжлалт бус газрын тосны ашиглалтын тусгай  
зөвшөөрлийн жагсаалт

№	Ордын нэр	Тусгай зөвшөөрөл дугаар	Эзэмшигч байгууллага	Нөөц баталсан шийдвэрийн он сар, өдөр, дугаар
1	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг орших Далай булагийн шатдаг занарын орд	17169А	"Мөнхий эрчит рашаан" ХХК	АМГ-ын даргын 2014-04-17 № н-60